



Цахим шууданд

ҮЖҮНХ



Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн удирдлага, ахлагчийн зөвлөлөөс ангийн болон алба хаагчдын ар гэрийн эмэгтэйчүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Уг арга хэмжээний зорилго нь гэр бүлийн бат тогтвортой харилцааг

бий болгох, тэдний ёс зүйн түвшнийг дээшлүүлэх, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, гэр бүлийн хөгжлийн орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой байв. Уг арга хэмжээнд ҮЖҮНХ-ийн уран бүтээлчдээс гадна МУСТА Дуучин Л.Чулуунбаатар, ЦДБЭЧ-ын Military Band хамтлаг эмэгтэйчүүдээ урлагийн тоглолт толилуулж хүндэтгэл үзүүлээ.

ТАНКИЙН ТУСГАЙ ХОРООНЫХОН “ЗӨВИЙГ ЗӨВЛӨЕ” УРИАНД НЭГДЛЭЭ



Зэвсэгт хүчний 256 дугаар анги

Ангийн бие бүрэлдэхүүн орон даяар хэрэгжиж байгаа “Зөвийг зөвлөе” согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аяныг Өвөрхангай аймгийн замын цагдаагийн тасаг болон Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сэтгэц наркологиын тасгийн эмч нартай хамтран мэдээлэл сурталчилгааны

ажлыг зохион байгуулж явууллаа. Уг сурталчилгааны ажлаар ангийн бие бүрэлдэхүүний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, архинаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга зам, хор уршгийн талаар сурталчлан таниулсан.

Хошууч Л.АМАРБАЯСГАЛАН

АХМАДУУДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Өнгөрсөн амралтын өдрүүдээр тус ангиас гавьяаныхаа амралтад байгаа ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлээ. Энэ үеэр Их-Уул цэргийн хүрээ ТББ байгууллагын удирдлага өнгөрсөн онд хийж бүтээсэн ажлын тайлангаа танилцуулсан.

Мөн ахлагч Ө.Солонго, дэд ахлагч А.Гантуяа нар ая дууны мэндчилгээ дэвшүүлж, бүжгийн “Ирмүүн” хамтлаг урлагийн тоглолт үзүүлсний зэрэгцээ ахмадуудынхаа санал, бодлыг сонсож, тэдний туршлагаас хуваалцсан юм.

МАРШ ТАКТИКИЙН АВАРГА ТАСАГ ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН ЭХЭЛЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөө, Баян-Өлгий аймгийн Засаг даргын баталсан “Баян-өлгий аймаг дахь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохиогдох 2022 оны марш тактикийн аварга тасаг шалгаруулах удирдамж”-ийн дагуу тэмцээн энэ сарын 11-ний өдөр Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн байрлалд гарааны өмнөх ажиллагаа дасгал нормативуудаар энэхүү ажиллагаа эхэлсэн юм.

Уг тэмцээнд Зэвсэгт хүчний 340, 331 дүгээр ангиуд, Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 116 дугаар тусгай салбар, Хилийн цэргийн 0165, 0285 дугаар ангиуд, Баян-Өлгий аймаг дахь

Цагдаагийн газар, Баян-Өлгий аймаг дахь Онцгой байдлын газар тус тус оролцож байна.

Жил бүр уламжлал болгон зохиогддог энэхүү тэмцээнд Зэвсэгт хүчний 340 дүгээр анги нь 2011 оноос хойш тасралтгүй оролцож байгаа бөгөөд 2012, 2013, 2016, 2017 онуудад “Тэргүүн байр”, 2011, 2014 онуудад “Дэд байр”, 2015, 2018, 2019 онуудад “Гутгаар байр”-ыг тус тус эзэлж байсан.

Энэ онд тус ангиас тасгийн захирагч хүнс, хувцасны хангалтын офицер, дэслэгч М.Сумьяабазар захирагчтай 11 цэргийн алба хаагч оролцож байна.



Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

ХУРАНДААГИЙН ДУРСАМЖ

Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Тус ангийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр өөрийн амьдралын алтан дурсамжуудаа хугацаат цэргийн алба хаагчдад хуваалцсан “Зураг түүх өгүүлнэ” дурсамжит уулзалт ярилцлагыг хийлээ.

Энэхүү уулзалтаар байлдагчаас хурандаа цол хүртэж, ангийн захирагчаар ажиллах хугацаандаа суралцаж ажилласан хөгтэй, хөгжилтэй мөчүүд,



мартагдашгүй дурсамжуудаа хуваалцсан юм.

Ангийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр түрүүч, байлдагч нарт хандан амьдралынхаа хором, мөч бүхэнд суралцаж өөрийгөө хөгжүүлж байхыг уриалаад хугацаат цэргийн алба хаагчдын сонирхсон асуултуудад дэлгэрэнгүй хариулт өглөө. Түрүүч, байлдагч нар уг ярилцлагаас их зүйл ойлгож авсан нь нүднээс нь илт харагдсан сэтгэл дүүрэн, инээд цалгисан сайхан арга хэмжээ боллоо.



ХҮНИЙ ЭД ХӨРӨНГИЙГ АВРАН ХАМГААЛЛАА

Завхан аймгийн Сонгино суманд байрлах иргэн Б-ийн хашаа, байшин 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн үүрээр 04 цаг 10 минутын үед их хэмжээний гал гард өртөж, шатаж байсныг Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай ротын бие бүрэлдэхүүн шуурхай арга хэмжээ авч тус сумын захиргаанд мэдэгджээ.

Улмаар тус салбарын орон тооны бус галын бүлгийг томилгоожуулж хажуугийн айлдгал орохоос урьдчилан сэргийлж, шатаж буй байшингаас эд хогшил болон шаардлагатай зүйлийг татан гаргаж чадсан гэв. Тэдний шуурхай ажиллагааны үр дүнд тэндхийн оршин суугчдаас эндэж, гэмтсэн тохиолдол гараагүй байна.

